



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай Г

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.7 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2007 оны 11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2011 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 276 дугаар тушаалд Агваан овогтой Энхтүвшинтэй холбогдох хэсгийн “Австрали Улсын Виктори их сургуулийн магистрантурт Барилгын материалын нанотехнологийн чиглэлээр” гэснийг “АНУ-ын Увиденер их сургуулийн магистрантурт инженерийн менежментийн чиглэлээр” гэж өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР